



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/378

Булган сум

**Нийлүүлэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Булган аймгийн зарим багийн Засаг дарга нарыг зөөврийн компьютерээр хангах (15 ш) нийлүүлэгчээр шалгарсан “Дижиталсервис” ХХК-тай 32 505 000 (гучин хоёр сая таван зуун таван мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т олгосугай.


2.Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Д.Эрдэнэбилэг)-т үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан барааг холбогдох хууль тогтоомж, техникийн үзүүлэлтийн дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Дижиталсервис” ХХК-ийн захирал (С.Оюунтунгалаг)-д даалгасугай.

4.Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5.Тус төсөл арга хэмжээний санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



6320010081

Аймгийн Засаг даргын 2023 оны  
05 дугаар сарын 7-ны өдрийн  
А/З.8 дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Тайлбар	Хариуцах албан тушаалтан
1	Бараа нийлүүлсний дараах чанарын болон баталгаат засварын хугацаа	1 жил	Д.Эрдэнэбилэг
2	Алданги	Хоног тутамд 0.1 хүртэл хувь байна.	Д.Батцогт